



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 02

Эрдэнэт

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах”
аймгийн дэд хөтөлбөр батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2020-2023 онд хэрэгжүүлэх “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” аймгийн дэд хөтөлбөрийг нэгдүгээр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрт тусгах, биелэлтийн явц, үр дүнг жил бүрийн 3 дугаар сард багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж байхыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д даалгасугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА

079110406

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны
01 дүгээр сарын 08-ны өдрийн
... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага, үндэслэл

Монгол улс 2011 онд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай” хуулийг баталж, хэрэгжилтийг хангахын тулд “Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр”-ийг 2017 онд батлан салбаруудын жендэрийн бодлого, стратеги, аймаг, нийслэлийн жендерийн дэд хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Хэдийгээр жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн орчин боловсронгуй болж, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр ахиц, дэвшил гарч байгаа боловч хууль хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлэх, санхүүжилтийг хүрэлцээтэй хуваарилах, хүний нөөцийг чадавхжуулах зэрэг нэн тэргүүнд шийдвэрлэх асуудал байсаар байна.

Иймд НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2015 оны Эх дэлхийгээ шинэчилье, 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан жендэрийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэхээр дэвшүүлсэн 5 дугаар зорилт, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх зорилт, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан, тэдгээрийн зорилтыг ханган ажиллахад орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийг боловсуулснаар нутгийн удирдлагын байгууллагын үр ашгийг дээшлүүлэн, түүний хэрэгжилт, хяналтыг дэмжих үр дүнтэй хэрэгсэл болно гэж үзэж байгаа юм.

Дэд хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд Орхон аймгийн Засаг даргын 2019 оны 07 сарын 23-ны өдрийн А/544 дугаар зарирамжаар ажлын хэсэг томилогдон, “Орхон аймгийн жендэрийн нөхцөл байдал, институцийн дүн шинжилгээ”-г аймгийн “Боловсрол дадлага” НҮТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан.

Судалгааны дүнд аймгийн хэмжээнд Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль, Үндэсний хөтөлбөр, жендэрийн асуудлаарх иргэд олон нийтийн мэдлэг, ойлголт дутмаг, жендэрийн хэвшмэл ойлголт давамгайлсан, байгууллагуудын хамтын ажиллагаа сул, жендэрт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл, ажлын байрны дарамт, залуу гэр бүлд ажил ар, гэр-амьдралын тэнцвэрийг хангаж ажиллах боломж нөхцөл тааруу гэх зэрэг жендэрийн үндсэн зарчмуудыг хангах үзүүлэлтүүд хангалтгүй байгаа нь жендэрийн дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байгааг илтгэж байна.

Дээрх судалгааны дүгнэлт, аймгийн үйл ажиллагааны бодлого төлөвлөлттэй уялдуулан Орхон аймгийн “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийг боловсруулсан.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1 Хөтөлбөрийн зорилго

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх, үндсэний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, орон нутгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг тодорхойлж, түүний хэрэгжилтийг ханган ажиллах тогтолцоо бүрдүүлэх замаар эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх тэгш оролцоог бий болгох, жендэрийн үзэл баримтлалыг бүх төвшинд бодлогоор дэмжих, нэвтрүүлэх, төлөвшүүлэхэд оршино.

2.2 Хөтөлбөрийн зорилтууд.

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхэд дараах үндсэн 3 зорилтыг дэвшүүлж байна.

Зорилт 1. Иргэд олон нийтэд, жендэрийн талаарх мэдлэг ойлголтыг сайжруулж, улс төр, эдийн засаг, нийгэм соёл, гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах

Зорилт 2. Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлтийг орон нутагт хэрэгжүүлэх чадавхийг бүрдүүлж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах.

Зорилт 3. Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалаас сэргийлэх бүх төрлийн үйл ажиллагааг зохион байгуулах

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2020-2023 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Зорилт 1. Иргэд олон нийтэд, жендэрийн талаарх мэдлэг ойлголтыг сайжруулж, улс төр, эдийн засаг, нийгэм соёл, гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах

1.1. Бүх нийтийн жендэрийн боловсролыг дээшлүүлэх, жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах

1.2. Гэр бүлийн харилцаанд үр хүүхдээ асран хамгаалах, өмч хөрөнгө эзэмшихэд гэр бүлийн гишүүдийн тэгш оролцоог хангах, гэр бүлийн хөгжлийг дэмжих бүх төрлийн үйл ажиллагаа зохион байгуулах

1.3. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэмжих замаар эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах

Зорилт 2. Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлтийг орон нутагт хэрэгжүүлэх чадавхийг бүрдүүлж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах

2.1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, жендэрийн үндэсний хөтөлбөр, орон нутгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, үр дүнтэй ажилласан байгууллага, иргэдийн санал санаачилга, манлайллыг дэмжих, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, урамшуулах

2.2. Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулагддаг танхимын болон цахим сургалтад төрийн болон төрийн өмчит байгууллагын хүний нөөцийн мэргэжилтэнүүдийг хамруулах, аймгийн хэмжээнд сургагч багш бэлтгэх

2.3. Баян-өндөр, Жаргалант сумдад жендэрийн салбар хороо байгуулж, аймаг сумын жендэрийн салбар хороо орон тооны болон орон тооны бус мэргэжилтэнтэй болох

2.4. Хүйсээр ангилсан мэдээллийн нэгдсэн санг баяжуулж, нэгдсэн бааз үүсгэж, мэдээллийг төрийн бодлогод ашиглаж, иргэд олон нийтэд түгээх

2.5. Төрийн болон төрийн өмчит байгууллагын хөдөлмөрийн харилцааг зохицуулсан баримт бичигт жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлыг тусган хэрэгжилтийг хангуулж ажиллах

Зорилт 3. Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалаас сэргийлэх бүх төрлийн үйл ажиллагааг зохион байгуулах

3.1. Хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах “Хохирогч хамгаалах байр” байгуулж, түүнд ажиллах боловсон хүчнийг бэлтгэх, сургах чиглэлээр бүх талын дэмжлэг үзүүлж ажиллах

3.2. Охид эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт нөлөөллийн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны
01 дүгээр сарын 08-ны өдрийн
... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ОРХОН АЙМГИЙН “ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨР”-ИЙГ
2020-2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№ 1. А 0052

№	ҮЙЛ АЖИЛЛАГАА	Шалгуу р үзүүлэл т	Хүрэх үр дүн	Хэрэгжилтий г хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэ х байгууллага	Хэрэгжи х хугацаа	Санхүүжилт /сая.төг/				
							2020 ОН	2021 ОН	2022 ОН	2023 ОН	Нийт
1	Зорилт 1. Иргэд олон нийтэд, жендэрийн талаарх мэдлэг ойлголтыг сайжруулж, улс төр, эдийн засаг, нийгэм соёл, гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах	1.1Бүх нийтийн жендэрийн боловсролыг дээшлүүлэх, жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	Жилд 5-аас доошгүй сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, 1000-аас доошгүй иргэдийг хамруулсан байна	Аймгийн болон сумдын жендэрийн салбар хороо, ГБХЗХГ	НТБТ, Төрийн болон төрийн бус байгууллагуу	2020-2023	-	10.0	8.0	8.0	26.0
2	1.2ЕБС-иудад охид, хөвгүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн сургалтын орчин бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах	Охид, хөвгүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн сургалтын орчин бүрдүүлсэн ЕБС-ийн тоо	Нийт ЕБС-иудын 80-аас доошгүй нь хувьд биеийн тамирын хувцас солих өрөө болон ариун цэврийн өрөөг охид хөвгүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн	Аймгийн болон сумдын жендэрийн салбар хороо, БСУГ	Төрийн болон хувийн хэвшлийн ЕБС-иуд	2020-2023	-	5.0	5.0	5.0	15.0

3	1.3 Гэр бүлийн харилцаанд үр хүүхдээ асран хамгаалах, өмч хөрөнгө эзэмшихэд гэр бүлийн гишүүдийн тэгш оролцоог хангах, гэр бүлийн хөгжлийг дэмжих бүх төрлийн үйл ажиллагаа зохион байгуулах	Гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр зохион байгуулсан сургалт нөлөөллийн арга хэмжээ болон хамрагдсан байгууллага, иргэдийн тоо	Жилд 5-аас доошгүй сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, 1000-аас доошгүй иргэдийг хамруулсан байна	Аймгийн болон сумдын жендэрийн салбар хороо, ГБХЗХГ	“Орхон аймгийн гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ, Төрийн болон төрийн бус байгууллагууд	2020-2023	5.0	3.0	3.0	11.0
4	1.3.Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэмжих замаар эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах	Эрэгтэйчүүдийн кабинетаар үйлчлүүлсэн иргэдийн тоо	Аймгийн нийт эрэгтэйчүүдийн 20-оос доошгүй хүрч хувьд үйлчилсэн байна.	Аймгийн болон сумдын жендэрийн салбар хороо, ЭМГ, БОЭТ, НЭМТ	Төрийн болон төрийн бус байгууллагууд	2020-2023	5.0	3.0	3.0	11.0
5	2. Зорилт Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлтийг орон нутаг хэрэгжүүлэх чадавхийг	Зохион байгуулсан туршлага солилцох, түгээн дэлгэрүүлсэн үйл ажиллагаа болон	Жилд 3-аас доошгүй байгууллагын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.	Аймгийн жендэрийн салбар хороо, ГБХЗХГ	Төрийн болон төрийн бус байгууллагууд	2020-2023	5.0	5.0	2.0	12.0

	<p>бүрдүүлж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах</p>	<p>ханган, үр дүнтэй ажилласан байгууллага, иргэдийн санал санаачилга, манлайллыг дэмжих, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, судлах, сурталчлах, урамшуулах</p>	<p>хамрагдсан байгууллага, иргэдийн тоо</p>								
6	<p>2.2. Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулагддаг танхимын болон цахим сургалтад төрийн болон төрийн өмчит байгууллагын хүний нөөцийн мэргэжилтнүүдийг хамруулах, аймгийн хэмжээнд сургагч багш бэлтгэх</p>	<p>Сургалтад хамрагдсан мэргэжилтнүүд болон орон нутгийн сургагч багш нарын тоо</p>	<p>Жилд 20-оос доошгүй сургагч багш бэлтгэгдсэн байна</p>	<p>Жендэрийн үндэсний хороо, Аймгийн жендэрийн салбар хороо</p>	<p>Төрийн болон төрийн бус байгууллагууд</p>	<p>2020-2023</p>	<p>5.0</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>5.0</p>
7	<p>2.3. Баян-өндөр, Жаргалант сумдад жендэрийн салбар хороо байгуулж, аймаг сумын жендэрийн салбар хороо орон тооны болон орон тооны бус мэргэжилтэнтэй болох</p>	<p>Жендэрийн салбар хороо байгуулагдаж хариуцсан мэргэжилтэн тэй болсон байна</p>	<p>Төр болон төрийн өмчит байгууллага бүрт жендэрийн салбар хороо байгуулагдсан байна</p>	<p>Аймгийн жендэрийн салбар хороо</p>	<p>Төрийн болон төрийн өмчит байгууллагууд</p>	<p>2020-2023</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>-</p>

	сэргийлэх чиглэлээр сургалт нөлөөллийн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах,	хамрагдсан байгууллага, иргэдийн тоо	байгуулж, 200-аас доошгүй иргэдийг хамруулсан байна	Тагнуулын газар	төрийн бус байгууллагууд					
12	3.3. Ажлын байран дахь удирдлагын болон бэлгийн дарамтаас ангид байх чиглэлээр төрийн болон төрийн өмчит байгууллагуудад сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах	Зохион байгуулсан сургалт нөлөөллийн арга хэмжээ болон хамрагдсан байгууллага, иргэдийн тоо	Төрийн болон төрийн өмчит байгууллага бүр жилд 2-аас доошгүй удаа сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж бүх ажилтан албан хаагчдаа хамруулсан байна	Төрийн болон төрийн өмчит байгууллагууд	Төрийн болон төрийн бус байгууллагууд	2020-2023				
Нийт										
-										
41.0										
30.0										
27.0										
98.0										

НБХ Нийгмийн бодлогын хэлтэс
 ХЭЗХ Хууль эрхзүйн хэлтэс
 БСУГ Боловсрол, соёл урлагийн газар
 ЭМГ Эрүүл мэндийн газар
 ГБХЗХГ Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
 ЦГ Цагдаагийн газар
 БОЭТ Бүсийн оношлогоо эмчилгээний төв
 НЭМТ Нийгмийн эрүүл мэндийн төв
 НТБТ Насан туршийн боловсрол олгох төв

3	1.3 Гэр бүлийн харилцаанд үр хүүхдээ асран хамгаалах, өмч хөрөнгө эзэмшихэд гэр бүлийн гишүүдийн тэгш оролцоог хангах, гэр бүлийн хөгжлийг дэмжих бүх төрлийн үйл ажиллагаа зохион байгуулах	Гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр зохион байгуулсан сургалт нөлөөллийн арга хэмжээ болон хамрагдсан байгууллага, иргэдийн тоо	Жилд 5-аас доошгүй сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, 1000-аас доошгүй иргэдийг хамруулсан байна	Аймгийн болон сумдын жөндөрийн салбар хороо, ГБХЗХГ	“Орхон аймгийн гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ, Төрийн болон төрийн бус байгууллагууд	2020-2023	-	5.0	3.0	3.0	11.0
4	1.3.Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэмжих замаар эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах	Эрэгтэйчүүдийн кабинетаар үйлчлүүлсэн иргэдийн тоо	Аймгийн нийт эрэгтэйчүүдийн 20-оос доошгүй хүрч хувьд үйлчилсэн байна.	Аймгийн болон сумдын жөндөрийн салбар хороо, ЭМГ, БОЭТ, НЭМТ	Төрийн болон төрийн бус байгууллагууд	2020-2023	-	5.0	3.0	3.0	11.0
5	2. Зорилт Жөндөрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлтийг орон нутаг хэрэгжүүлэх чадавхийг	Зохион байгуулсан туршлага солилцох, түгээн дэлгэрүүлсэн үйл ажиллагаа болон	Жилд 3-аас доошгүй байгууллагын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.	Аймгийн жөндөрийн салбар хороо, ГБХЗХГ	Төрийн болон төрийн бус байгууллагууд	2020-2023	-	5.0	5.0	2.0	12.0